



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/463

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн  
сургалтаас хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан 'Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/456 дугаар тушаалаар хуваарилсан үндсэн мэргэшлийн сургалтаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан "Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтаас хасах 2 резидент эмчийн нэр, мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэр"-ийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:
  - 2.1 Нэр бүхий 2 резидент эмчийг үндсэн мэргэшлийн сургалтаас чөлөөлсөн талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлэх;
  - 2.2 Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллага Эмгэг судлалын үндэсний төв /Г.Уянга/-д албан бичгээр мэдэгдэх;
  - 2.3 Сургалтын төлбөр, тэтгэлэгтэй холбоотой нийт зардлыг гэрээний дагуу холбогдох журмын хүрээнд нөхөн төлүүлэх.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141201791



**ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТААС ХАСАХ 2 РЕЗИДЕНТ ЭМЧИЙН НЭР,  
МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭР**

№	Эцэг/эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар, Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Дипломын дугаар	Төгссөн сургууль	Захиалагч эрүүл мэндийн байгууллага /хувийн зардлаар суралцагчдын харьяалал/	Үндсэн мэргэшлийн чиглэл	Төлбөрийн хэлбэр	Сургалт эрхлэх байгууллага	Үндсэн мэргэшлийн сургалтад элссэн огноо, тушаалын дугаар
1.	Ядамсүрэн	Мөнхнасан	ПБ95030723 ИЭ9911302	D201820741	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	Ховд Булган сумын Сум дундын эмнэлэг	Анатомын эмгэг судлал	Төрийн сан	Эмгэг судлалын үндэсний төв	2020.10.04 Эрүүл мэндийн сайдын А/456 дугаар тушаал
2.	Ган-Очир	Занданбилэг	ПЮ93102906 ИЭ9911284	D201905474	Ач Анагаах ухааны их сургууль	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	Анатомын эмгэг судлал	Хувь хүн	Эмгэг судлалын үндэсний төв	2020.10.04 Эрүүл мэндийн сайдын А/456 дугаар тушаал